

**ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр

Хэрлэн сум

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлт, хугацаа	Биелэлт
1	Албан хаагчдыг бүртгэлийн байгууллага болон Засгийн газар, төрийн бусад байгууллагаас зохион байгуулах албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зохион байгуулах дотоод сургалтуудад суралцах боломжоор хангах	I II III IV	Сургалтын агуулгыг олон төрөл хэлбэрээр явуулна.	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын тоо	<p>Тус хэлтэс нь 2024 онд 4 бүлэг 17 заалт бүхий сургалтын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлант хугацаанд нийт 88 сургалтад давхардсан тоогоор 1400 гаруй албан хаагч хамрагдсан. Үүнээс:</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 34 удаагийн онлайн сургалтад /бүртгэлийн чиглэлээр-18, сонгууль-7, бусад -7/, танхимын 2 удаагийн сургалтад 2 албан хаагч, бүсийн сургалтад 15 албан хаагч, давхардсан тоогоор нийт 430 албан хаагч хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 4:7:10/ 18 удаагийн сургалт, өөрсдийн нөөц боломжид тулгуурлан төрийн байгууллагатай хамтран зохион байгуулсан, 36 нэр төрлийн сургалтад давхардсан тоогоор 976 албан хаагч хамрагдсан.</p>
2	Гадаад улсад албан хаагчдыг хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрийн сургалтад байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар	I II III IV	Албан хаагчид 5-с доошгүй улс оронд очин туршлага судалсан байна.	Хамрагдсан төсөл хөтөлбөр болон сургалтын тоо, хамрагдсан албан хаагчийн тоо	Бүгд найрамдах Солонгос улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Койка/-ын санхүүжилтээр хэрэгжиж буй "Монгол улсын бүртгэлийн системийн чадавхыг бэхжүүлэх 2023-2025" төслийн 2

	суралцуулах				дахт удаагийн сургалтын нээлтийн арга хэмжэнд Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ж.Ганзориг хамрагдсан.	
3	Цалин хөлс, шагнал урамшууллын хэрэгжүүлэх	тогтолцоог	I II II IV	Нийт албан хаагчийн хувийг хамруулна. 80	Ил тод байх, цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардал, байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	Хэлтсийн 2024 оны нийт 878 059 900 төгрөгний төсвөөс цалин хөлс, шагнал урамшуулалд 664 747 838,09 төгрөг буюу 75,7 хувийг зарцуулсан.
4	Албан хаагчдын ажиллах хэвийн нөхцлийг бүрдүүлэх		I III II IV	Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн шинэ байрны барилга угсралтын ажлыг дуусгана.	Ашиглалтад орсон байна	Ажлын байрны нөхцөл байдал, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргад саналыг хүргүүлснээр шинээр ашиглалтад орсон Нутгийн удирдлагын ордны зүүн жигүүр буюу Б корпуст архивын 2 өрөө, үйлчилгээний 2 танхим, цахим 1 танхим, албан хаагчдын 5 өрөөг тус тус шийдвэрлүүлэн иргэдэд үйлчилдэг танхимиын ширээ сандлыг шинээр сольж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн. Аймгийн Засаг даргад төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд шаардлагатай компьютер тоног төхөөрөмжийн судалгаа саналыг хүргүүлснээр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажилд дэмжлэг үзүүлж компьютер, сканнер, принтер зэрэг тоног

					төхөөрөмжүүдийг шийдвэрлүүлсэн. /Үнийн дүн 34.548.400 төгрөг/
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	I II II IV	2-оос доошгүй ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан ажил, хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь	<p>Зүүн бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй хамтран хэлтсийн шинээр томилогдсон 5 албан хаагчдыг эрүүл мэндийн эрт илрүүлгийн багц үзлэгт 5 дугаар сард хамруулсан.</p> <p>Мөн хэлтсийн албан хаагчдыг элэгний В, С вирус, сахарын шинжилгээнд бүрэн хамруулж, холбогдох албан хаагчдад зөвлөгөө авч, эмчилгээнд хамруулсан.</p> <p>11 дүгээр сарын 20-ны өдөр 21 албан хаагчдыг эрүүл мэндийн эрт илрүүлгийн багц үзлэгт хамруулахаар төлөвлөгөөнд тусгагдсан.</p>
6	Салбарын албан хаагчдын гэр бүлд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний судалгааг гарган тэдгээрт дэмжлэг үзүүлэх, амьжирааг дэмжих ажлыг зохион байгуулах	I II II IV	2-оос доошгүй ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулсан ажил, дэмжлэг үзүүлсэн тоо	<p>Нэгдсэн судалгааг гаргаж системд тусгасан. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-ийн хэл заслын өдрийн эмчилгээнд 5 хоног хүүхдээ хамруулсан 1 албан хаагчид цагаар чөлөө олгосон.</p> <p>Мөн 03 дугаар сарын 21-ний өдрийн “Даунтай хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулан зохион байгуулсан эмчийн үзлэг, спорт тэмцээнд хүүхдээ хамруулсан 1 албан хаагчид ажлын 1 өдрийн цалинтай чөлөө олгосон.</p> <p>Хэлтсийн даргын А/25 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 албан хаагчид 549 888 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн. УБЕГ-ын Б/579 тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 2 албан хаагчдад 2,904,000 төгрөгийн мөнгөн</p>

					тусlamж үзүүлэх тушаалын дагуу 12 дугаар сард өгөхөөр төсөвлөсөн.
7	Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, дэмжих ажлыг зохион байгуулах	I II III IV	1 арга хэмжээ зохион байгуулсан байна.	Зохион байгуулсан ажил, дэмжлэг үзүүлсэн тоо	Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хэлтсийн даргын А/25 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй 1 албан хаагчид 549 888 төгрөгийн мөнгөн тусlamж үзүүлсэн.
8	Албан хаагчид, түүний гэр бүлд гачигдал, тэмдэглэлт үйл явдал тохиолдоход байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан мөнгөн тусlamжийг олгох	I II III IV	Хүсэлт шийдвэрлэлтийн хувь 90 % байна.	Хүсэлт шийдвэрлэлтийн хувь	Хэлтсийн даргын 2024 оны Б/04, Б/26 дугаар тушаалаар хэлтсийн 2 албан хаагчийн шинээр хүүхэд төрсөн хүүхдэд 200.000 төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон.
9	Өндөр насын тэтгэвэрт гарсан албан хаагчдыг жилд 1 удаа удирдлага хүлээн авч уулзах, ахмадын өдөр, сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлэх	I II III IV	2-оос доошгүй ажлыг зохион байгуулна	Зохион байгуулсан ажил, хамрагдсан ахмад ажилтны тоо	Өндөр насын тэтгэвэрт гарсан 6 ахмад ажитнуудад сар шинийн баяр болон ахмадын өдрөөр хүндэтгэл үзүүлэх уулзалт зохион байгуулах, гарын бэлэг гардуулдаг бөгөөд жил бүрийн улсын бүртгэлийн байгууллагын үүсэж хөгжсөний ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд ахмадуудыг урилгаар оролцуулж хэвшсэн. Сар шинийн баяраар 6 ахмадад 898,840 төгрөг, Ахмадын баяраар 810,000 төгрөгийн үнэ бүхий гарын бэлгийг ахмадын сангаас гардуулсан.
10	Хамт олны дунд спорт өдөрлөгийг 2-3 удаа зохион байгуулах	I II III IV	Спортын олон төрөл, хэлбэрээр зохион байгуулна	Зохион байгуулсан ажил, хамрагдсан албан хаагчийн эзлэх хувь	Албан хаагчдын чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Тагнуул, Прокурор, Гаалийн газруудтай хамтран 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр “Цас мөс”-ний баярыг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд ирсэн албан хаагчдыг 5

					багт хуваан мөсөн шагай, хөл бөмбөг, морин барилдаан, олс таталт зэрэг тэмцээн зохиож, эрүүл агаарт зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлж ажилласан. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас Дорнод аймагт зохион байгуулсан бүсийн сургалтын “Буйр-2024” урлаг, соёлын арга хэмжээг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулж, Баян-Өлгий аймагт зохион байгуулсан сургалтад хамрагдсан.
11	Хариуцсан ажилдаа амжилт гаргасан хамт олноо манлайлсан албан хаагчдад удирдлагын шийдвэрээр гадаад оронд хувийн зардлаар аялах боломжийг дэмжиж ажиллах	I II III IV	Хүсэлт шийдвэрлэлтийн хувь 50 % байна	Хүсэлт шийдвэрлэлтийн хувь	Хэлтсийн албан хаагчдын хамт олонч уур амьсгалыг бий болгох, байгууллагын соёлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн уламжлалт өвлийн аялалыг БНХАУ-ын Манжуур хотод зохион байгуулсан. Уг аялалд 11 албан хаагч хамрагдсан бөгөөд УБЕГ-аас 2 хоногийн цалинтай чөлөөг авах хүсэлт хүргүүлж, шийдвэрлүүлж ажилласан.
12	Байгууллагын хүүхдийн эрх хамгааллын ажлын хүрээнд хийгдсэн хүүхэд хичээл сургууль, цэцэрлэгээ тараад эцэг эхийнхээ ажил дээр ирэх тохиолдолд тоглох, хөгжих, хичээлээ хийх боломжоор хангаж, хүүхдийн өрөөний хэвийн ўлт ажиллагааг хангаж тогтмол ажиллуулах	I II III IV	Үйлчлүүлсэн хүүхдүүдийн тоо	Журмыг баталж хэрэгжүүлэх	Аймгийн нутгийн удирдлагын ордны 2 давхарт байрлах хүүхдийн өрөөг агентлаг хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдэд зориулж, аймгийн Засаг даргын тамгын газар бүрэн тохижуулсан бөгөөд хэлтсийн албан хаагдын бага насны 6 хүүхэд уг өрөөнд тогтмол очиж, цагийг өнгөрүүлдэг.
13	Байгууллагын дэргэдэх эцэг	I II III IV	2-оос доошгүй	Зохион	Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл

	эхийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмол явуулах		ажлыг зохион байгуулна	байгуулсан ажил	нь 2017 оноос хойш тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд “Эх үрсийн баярын өдөр”-ийн үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлсэн. Мөн 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “Миний гэр бүл” сэдэвт гар зургийн уралдаан зохион байгуулж, оролцогч хүүхдүүдээ гарын бэлэг, дурсамж бүхий эд зүйлээр шагнаж, урамшуулсан.
14	Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оноос хойш хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах	IV	Хөтөлбөрийн төсөл боловсруулагдан байна.	Холбогдох газар хэлтсээс санал авч, нэгтгэгдэж эцэслэсэн байх	Төслийн санал ирүүлээгүй.

ХЯНАСАН:
 Д.ОЮУНБАЯР
 ХЭЛТСИЙН ДАРГА: Д.УУГАНЧИМЭГ
 ТАЙЛАН БИЧСЭН:
 УЛСЫН БҮРТГЭГЧ
